



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/27

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 зүйлийн 60.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/03 дугаар тогтоолоор батлагдсан Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1.7, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 07/08 дугаар тогтоолын 3.2.1.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, түүний Тамгын газрын бодлого, шийдвэр, үйл ажиллагааг иргэдэд ил тод, хүртээмжтэй хүргэх ажлыг төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудаар гэрээгээр гүйцэтгүүлэх зардлыг хавсралтаар баталсугай.

2. Төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан, гүйцэтгэлийн дагуу батлагдсан зардлаас санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0059

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2022 оны
01 дүгээр сарын 26-ны өдрийн
.....дугаар захирамжийн
хавсралт

Төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудаар
2022 онд гэрээгээр гүйцэтгүүлэх ажлын
зардлын хуваарь

Д/д	Хэвлэл мэдээллийн байгууллагуудын нэр	Санхүүжилт
1.	МҮОНТ-ийн Орон нутаг дахь сэтгүүлч	6,000,000
2.	“Соёмбо” телевиз	6,000,000
3.	“Хас” телевиз	6,000,000
4.	“Арвайхээр чөлөөт суваг” телевиз	6,000,000
5.	Uvlive.mn сайт	6,000,000
6.	“Өвөрхангайн өнгө” сэтгүүл	5,000,000
7.	“Өвөрхангайн мэдээ” сонин	5,000,000
8.	“Ноён-Уул” богино долгионы радио	4,000,000
9.	Монголын радиогийн сурвалжлагч	2,000,000
10.	Өв брэнд консалтинг ХХК	2,000,000
11.	Төвийн хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах	12,000,000
НИЙТ		60,000,000